

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

ажлын явцтай танилцав

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/-ын бүсийн байгууллага болох Ази, номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн дарга Он Сян Сун тэргүүтэй дээд хэмжээний төлөөлөгчид манай улсад 2010 оны 3 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд ажлын айлчлал хийлээ.

Монгол Улс нь энэ байгууллагад 2004 онд гишүүнээр элссэнээс хойш тус байгууллагын үйл ажиллагаанд байнга идэвхитэй оролцож, ФАТФ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг шат дараалан авч байна.

Айлчлалын хүрээнд төлөөлөгчид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудад зочилж, холбогдох албан тушаалтнуудтай уулзан энэ чиглэлээр манай улсаас авч хэрэгжүүлж байгаа ажилтай танилцлаа. Түүнчлэн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын стандартын талаар төрийн байгууллагын ажилтнуудад хагас өдрийн сургалт зохион байгуулав.